

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

*ДХИС-ийн ОБС-ийн Гамшгаас хамгаалах албаны тэнхимийн Гамшгаас
хамгаалах албаны тэнхимийн багш, ахлах дэслэгч, Б.Ням-Уяа*
nyamuuya0413@gmail.com

Товчлол: Энэхүү илтгэлд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтад шинжилгээ хийхдээ Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль болон хуулийн заалттай нийцүүлэн боловсруулагдсан бодлогын баримт бичиг гэсэн хоёр чиглэлээр хийв.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын онцлог нь гамшгийн эрсдэлийг бууруулах бодлого стратегийг хэрэгжүүлэхэд чиглэсэн, нийгмийн амьдралын олон талт харилцааг хамарсан олон тооны хуулиуд, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудаас бүрддэг явдал юм.

Бид судалгааны үр дүнд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд гамшгаас хамгаалах тухай болон холбогдох бусад хуулиудаас бүрдэх эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж, ямар үр дүнтэй байгааг нотлохыг зорьлоо.

Түлхүүр үг: Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, хууль, бодлого, хөтөлбөр, журам

Оршил

Гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэхэд үр дүнтэй эрх зүйн зохицуулалт зайлшгүй хэрэгтэй. Учир нь гамшгаас хамгаалах бодлого, үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах төрийн дотоод чиг үүрэгт хамаарах ба энэ салбарын хүрээнд батлан гаргасан бодлого шийдвэр, хууль, хуульчилсан эрх зүйн актуудгүйгээр хэрэгжих боломжгүй юм.

Гамшгийн эрсдэлийг үр дүнтэй бууруулахад гамшгаас хамгаалах тухай болон холбогдох бусад хуулиудаас бүрдэх эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх хэрэгцээ шаардлага урган гарсаар байна.

1994 онд Монгол Улсын Иргэний хамгаалалтын тухай хууль батлагдсанаар иргэний хамгаалалтын тухай ойлголтыг цогц байдлаар хуульчилсан бол 2003 онд Монгол Улсын гамшгаас хамгаалах тухай хуулийг батлан гаргаснаар гамшгаас хамгаалах үйл ажиллагааны шинэ эрх зүйн орчин бүрдсэн билээ.

Харин 2017 онд Гамшгаас хамгаалах тухай хуулийг шинэчлэн найруулахдаа гамшгийн эрсдэлийн менежментийн асуудлыг орчин үеийн гамшгаас хамгаалах бодлого, стратегид нийцүүлэн илүү боловсронгуй болгон хуульчилсан юм.

Үндсэн хэсэг

Гамшгийн эрсдэлийн менежментийн эрх зүйн зохицуулалтын мөн чанар нь дэлхийн болон Монгол улсын нийгэм, улс төр, эдийн засаг, өнөөгийн гамшгийн эрсдэлт нөхцөл байдалд тохирсон, гамшгийн эрсдэлийг бууруулах бодлого стратеги, гамшгийн эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэхэд чиглэсэн, нийгмийн амьдралын олон талт харилцааг хамарсан, эрх бүхий олон субъектээс батлан гаргасан төрийн байгууллага, аж ахуйн нэгж, нийт иргэд заавал даган биелүүлэх хууль болон хуульд нийцүүлэн гаргасан эрх зүйн актууд байдагт оршино.

Бидний хийсэн судалгаагаар гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын шинжилгээг Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль болон хуулийн заалттай нийцүүлэн боловсруулагдсан бодлогын баримт бичиг гэсэн хоёр чиглэлээр хийв.

Нэг. Монгол Улсын хуулиуд: Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулиас одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудаас гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаатай холбоотой зүйл заалтыг судалж үзлээ.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны эрх зүйн орчинг бүрдүүлж байгаа хуулиудыг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 1. Монгол Улсын хуулиуд

Д/д	Хууль	Зүйл заалт нь шууд туссан, Шууд бус туссан
1	Монгол Улсын Үндсэн хууль ²³	16.1.Монгол Улсын иргэн <i>амьд явах</i> эрхтэй..., 16.2. <i>эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах</i> эрхтэй.
2	Үндэсний аюулгүй байдлын тухай хууль ²⁴	11.1.Бүх шатны засаг дарга үндэсний аюулгүй байдалд <i>хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас сэргийлэх</i> , таслан зогсоох, түүний шалгаан нөхцөлийг судлан тогтоох, арилгах арга хэмжээг авч, энэ асуудлаар нутаг дэвсгэртээ байгаа үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй албадад чиглэл өгч, холбогдох байгууллагад санал, хүсэлт тавина

²³ Монгол Улсын Үндсэн хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. №01. 1992.

²⁴ Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. №3. 2002.

3	Гамшгаас хамгаалах тухай хууль ²⁵	Энэ хуулийн 9 дүгээр зүйл. <i>Гамшигийн эрсдэлийг бууруулах</i> арга хэмжээг тусгасан. 22 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, 27 дугаар зүйл.Үндэсний болон орон нутгийн зөвлөлийн бүрэн эрх, 31 дүгээр зүйл.Нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, 32 дугаар зүйл.Засаг даргын бүрэн эрх, 33 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах албаны чиг үүрэг, 34 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн эрх, үүрэг, 35 дугаар зүйл.Төрийн бус байгууллагын эрх, үүрэг, 51 дүгээр зүйл.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт зэрэг зүйл, заалтад <i>гамшигийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны</i> хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой тусгасан.
4	Галын аюулгүй байдлын тухай хууль ²⁶	Галын аюулгүй байдлыг хангах, гал түймрээс урьдчилан сэргийлэх, аврах хамгаалах, унтраах, гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх зэрэг харилцааг зохицуулна.
5	Улсын нөөцийн тухай хууль ²⁷	5.1.2.эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор зах зээл дэх зарим бараа, материалын эрэлт, нийлүүлэлтийн харьцааг тэнцвэржүүлэхэд дэмжлэг үзүүлэх; 17.1.2.онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг үндэслэн нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, зарцуулах, сэлгэх, шинэчлэх, тээвэрлэж хүргэх үйл ажиллагааг эрхлэх;
6	Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай ²⁸	6.2.3.гамшиг, гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг бууруулах, нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулах, нэрвэгдэгсдэд яаралтай тусламж үзүүлэх, хүн амд гамшигийн үед арга хэмжээ авах талаар мэдлэг олгох; 6.3.2.гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахад туслах, эрсдэлийг бууруулах, нэрвэгдэгсдэд яаралтай тусламж, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх;
7	Монгол Улсын Засгийн газрын тухай ²⁹	11.4.Гамшиг болон аюул, орчны ноцтой бохирдолтоос сэргийлэх, тэдгээрээс учирсан хор уршгийг арилгахад улс, олон нийтийн байгууллага, иргэдийн хүчийг нэгтгэн зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээ авна.
8	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль ³⁰	11.1.Засгийн газрын нөөц сан нь тухайн жилийн төсөвт урьдчилан тооцож, төлөвлөн тусгах боломжгүй, хойшлуулшгүй цаг үеийн шинжтэй арга хэмжээ болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.8-д заасан гамшигийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, 4.1.15-д заасан гамшигийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг шат дараатай зохион байгуулах зорилгоор улс, орон нутгийн

²⁵ Гамшгаас хамгаалах тухай “Төрийн мэдээлэл” эмхэтгэл №7. 2017.

²⁶ Галын аюулгүй байдлын тухай “Төрийн мэдээлэл” эмхэтгэл №28. 2015.

²⁷ Улсын нөөцийн тухай “Төрийн мэдээлэл” эмхэтгэл №30. 2007.

²⁸ Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай “Төрийн мэдээлэл” эмхэтгэл №5. 2016.

²⁹ Монгол Улсын Засгийн газрын тухай “Төрийн мэдээлэл” эмхэтгэл №3. 1993.

³⁰ Засгийн газрын тусгай сангийн тухай “Төрийн мэдээлэл” эмхэтгэл №48. 2019.

		төсвийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлын хүрэлцэхгүй хэсгийг санхүүжүүлэх зориулалттай байна.
9	Хүүхэд хамгааллын тухай хууль ³¹	2.2.Хүүхэд хамгаалал нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ. 9.1.Худалдаа үйлчилгээ, соёлын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, арга хэмжээ, олон нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал цуглаан, замын хөдөлгөөн, хүүхэд оролцсон шалгалт, уралдаан тэмцээний үед хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх үүргийг зохион байгуулагч болон оролцогч талууд ханган ажиллана.
10	Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай ³²	1.1.Энэ хуулийн зорилт нь олон улсын худалдааны чөлөөт байдлыг дэмжих, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл, шаардлагыг хангуулах, аюулгүй байдлыг баталгаажуулж холбогдох гэрчилгээ олгох, хяналт, шалгалт хийх, улсын хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.


Монгол Улсын хуулиудад салбар, салбарын ашиг сонирхол, үйл ажиллагааны онцлогийг гаргасан эрсдэл, түүнээс сэргийлэхтэй холбогдох нийтээр даган мөрдөх заалтууд тодорхой хэмжээгээр тусгалаа олсон байна. Тухайлбал, Монгол Улсын 50 гаруй хуулиуд Гамшгаас хамгаалах тухай хуультай нийцүүлэн эрсдэлийн талаар тусгагдсан хэдий ч үүнээс 10 хуулийг сонгож шууд болон шууд бус тусгагдсан заалтаар нь тодорхойллоо.

Дээрх 10 хуулиудад гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны талаарх асуудал олон салбарын оролцоог шаардсан цогц асуудал болохыг харуулахын зэрэгцээ цаашид салбар хоорондын түншлэлийн харилцаа, зохицуулалтад анхаарах хэрэгтэй байна. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа нь улс орны тогтвортой хөгжлийг хангахад чиглэгддэг учраас Засгийн газар, төрийн байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, олон нийтийг татан оролцуулах шаардлагатай ба эрх, үүрэг, хариуцлагын тогтолцоог тодорхой зааж тусгах шаардлагатай байна.

³¹ Хүүхэд хамгааллын тухай “Төрийн мэдээлэл” эмхэтгэл №9. 2016.

³² Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай “Төрийн мэдээлэл” эмхэтгэл №46. 2002.

Хоёр. Бодлогын баримт бичгийн шинжилгээ: Бодлогын баримт бичгийн шинжилгээнд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал тэдгээрийн агуулгыг тусгасан бусад бодлогыг хамруулан авч үзсэн



Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”³³ нь гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг бүрэн хамруулах боломжтой юм.

Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг үндэсний аюулгүй байдлыг хангах бүрэлдэхүүн хэсгийн хангах арга замын хүрээнд дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1). *Соёл иргэний аюулгүй байдлыг хангах хүрээнд:* “Уламжлалт Бурханы шашин, соёлыг сэргээн хөгжүүлж, сүм хийдийн үйл ажиллагааг нийгмийн оюун санааг гэгээрүүлэх, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, ядуурлыг бууруулах, зовлон гамшигт нэрвэгдсэн хүн ардад туслалцаа үзүүлэх, байгаль орчныг хамгаалах үйлсэд чиглүүлэхэд төрөөс анхаарч, дэмжлэг үзүүлнэ.”,

2). *Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах хүрээнд:* “Газрын тосны бүтээгдэхүүнээр нэг орноос шууд хараат байдлыг багасгаж, улмаар 2020 он гэхэд дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээгээ бүрэн хангана. Үнийн хэт хэлбэлзэлд өртөх эрсдэлээс сэргийлж, улсын нөөцийг түүхий нефтээр 6 сараас доошгүй хэмжээнд байлгана.”,

3). *Хүний аюулгүй байдлыг хангах хүрээнд:* а). “Халдварт өвчний нийтийг хамарсан тархалт, гамшгийн үед авах арга хэмжээний бэлэн байдлыг хангаж,

³³ Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. №48. 2010.

урьдчилан сэргийлэх эм, тарилга, вакцин, био бэлдмэлийн улсын нөөцийг бүрдүүлнэ.”, б). “Гамшиг, онцгой нөхцөл байдлын үед шаардлагатай эмнэлгийн тусламжийг хүн амд шуурхай хүргэх чадавхыг байнга дээшлүүлнэ.”, в). “Стратегийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг баталгаажуулах урт хугацааны тогтвортой гэрээ байгуулах, гамшгийн үед хэрэглэх стратегийн хүнсний бүтээгдэхүүний улсын нөөц, хот, суурин газрын хүн амын хүнсний эрэлт нийлүүлэлтийг тогтвортой байлгах улирлын нөөцийг бүрдүүлэх замаар хүнсний хангамжийн баталгааг хангана.”, г). “Хүнсний бүтээгдэхүүнийг зөвхөн аж ахуйн нэгж, байгууллагаар дамжуулан импортлох тогтолцоог бүрдүүлж, импортын хүнсний бүтээгдэхүүнд чанарын урьдчилсан хяналт, бүртгэлжүүлэлт, баталгаажуулалтын нэгдмэл тогтолцоо бий болгох, импортлох үеийн чанарын баталгаат байдалд эрсдэлийн үнэлгээ хийх замаар чанар, аюулгүй байдлын баталгааг хангана.”, д). “Нанотехнологи, биотехнологийн эрсдэлийг үнэлэх, хянах, түүний хор хөнөөлөөс хамгаалах арга хэмжээ авна.”,

4). Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах хүрээнд: а). “Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авна.”, б). “Гамшгийн менежментийн тогтолцоог бэхжүүлж эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж, төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлж, чадавхыг бэхжүүлнэ.”, в). “Байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, урьдчилан мэдээлэх арга, технологи нэвтрүүлэх, хяналт-шинжилгээний сүлжээний тасралтгүй ажиллагааг хангах техник хэрэгсэл, хүний нөөцийг системтэйгээр бэлтгэж, мэдээллийг хэрэглэгчид шуурхай хүргэх арга замыг боловсронгуй болгон эртнээс сэрэмжлүүлэх чадавхыг бүрдүүлнэ.”,

5). Мэдээллийн аюулгүй байдлыг хангах хүрээнд: а). “Төр, хувийн хэвшлийн байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын бодлого, дэг, эрсдэлийн удирдлага, дотоод аудит, үнэлгээний чадавхыг бий болгоно.”, б). “Мэдээллийн аюулгүй байдлын орчин үеийн дэвшилтэт, өртөг багатай шийдлийг зөвхөн эрсдэлийн үнэлгээний үндсэн дээр сонгон ашиглана. Төрийн байгууллага, онц чухал дэд бүтцийн объектын мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг өндөр түвшинд бэлтгэгдэж, итгэмжлэгдсэн үндэсний мэргэжилтнээр гүйцэтгүүлнэ” гэж тус тус тодорхойлсон нь үндсэндээ үндэсний аюулгүй байдлыг хангах бүрэлдэхүүн хэсгийг бүхэлд нь хамарсны зэрэгцээ хүний болон хүрээлэн буй орчны аюулгүй байдалтай бусдаас илүүтэй холбон авч

үзсэн байна. Энэ нь гамшгийг эрсдэлийг бууруулах нь тэдгээрийг хангах баталгаа, үндэс болдогтой холбоотой байна. Мөн гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны үр дүнг Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл үнэлж дүгнэж байх ёстойг онцолсон байна.

Судалгаанаас үзэхэд гамшгийн эрсдэлийн менежментийн явц, хэрэгжилт үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн удирдлага, зохицуулалтын хүрээнд хяналт үнэлгээ хийгдэж, дүгнэгдэж, боловсронгуй болж байх ёстой нь үзэл баримтлалын заалтаас харагдаж байна.

Мөн бүх салбарыг хамарсан хөгжлийн бодлого, хөтөлбөрт “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ 2015-2030” баримт бичгийн “гамшгийн эрсдэлийг ойлгох” чиглэлийг сонгож, нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлийг ойлгох үнэлгээ, мэдээлэл солилцох, зөвлөлдөх, хамтран ажиллах, эрсдэлийг бууруулах арга хэмжээ, үйл ажиллагаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд шинжилгээ хийсэн.

Хүснэгт №2. Гамшгийн эрсдэлийн менежментийн “гамшгийн эрсдэлийг ойлгох” чиглэлийн хүрээнд бүх салбарыг хамарсан хөгжлийн бодлого, хөтөлбөрт хийсэн шинжилгээ³⁴

Д/д	Бүх салбарыг хамарсан хөгжлийн бодлого, хөтөлбөр	Нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлийг ойлгох үнэлгээний хүрээнд	Мэдээлэл солилцох, зөвлөлдөх, хамтран ажиллах хүрээнд	Эрсдэлийг бууруулах арга хэмжээ, үйл ажиллагааны хүрээнд	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд
1	Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого				
2	Ногоон хөгжлийн бодлого				
3	Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого				
4	Гурван тулгуурт хөгжлийн бодлого				
5	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр				
6	Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр				
7	Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр				
8	Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр				
9	Цөлжилттэй дэмжих үндэсний хөтөлбөр				

³⁴ Саранцэцэг Б., “Гамшгийн эрсдэлийн менежмент” нэг сэдэвт бүтээл. Уб., 2024 он

Дээр авч үзсэн бүх салбарыг хамарсан хөгжлийн бодлого, хөтөлбөрт гамшгийн эрсдэлийн менежментийн “гамшгийн эрсдэлийг ойлгох” чиглэлийн хүрээнд гамшгийн эрсдэлийн үйл ажиллагааны асуудлыг Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Гурван тулгуурт хөгжлийн бодлогод гамшгийн эрсдэл, түүнээс үүдэлтэй хохирлыг бууруулах арга хэмжээнүүдийг төлөвлөснөөс гадна гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хөгжлийн бодлоготой уялдуулсан байгаа нь гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны талаарх чухал баримт бичгүүд болж байна.

Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний үалгуур үзүүлэлт, хүрэх түвшин нь бусад бодлогын баримт бичгийн тулгуур баримт бичиг болсон нь давуу тал ажиглагдлаа. Бусад бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн тодорхой үр дүн харагдахгүй байгаа нь эрсдэлийн менежментийн төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, гүйцэтгэл, хариуцлага, тайлагнах тогтолцоо муу байгааг харуулж байна.

Салбарын түвшингийн бодлого, хөтөлбөрт “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ 2015-2030” баримт бичгийн “гамшгийн эрсдэлийг ойлгох” чиглэлийг сонгож, нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлийг ойлгох үнэлгээ, мэдээлэл солилцох, зөвлөлдөх, хамтран ажиллах, эрсдэлийг бууруулах арга хэмжээ, үйл ажиллагаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд шинжилгээ хийсэн.

Хүснэгт №3. Гамшгийн эрсдэлийн менежментийн “гамшгийн эрсдэлийг ойлгох” чиглэлийн хүрээнд салбарын түвшингийн бодлого, хөтөлбөрт хийсэн шинжилгээ

Д/д	Салбарын түвшингийн бодлого, хөтөлбөр	Нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлийг ойлгох үнэлгээний хүрээнд	Мэдээлэл солилцох, зөвлөлдөх, хамтран ажиллах хүрээнд	Эрсдэлийг бууруулах арга хэмжээ, үйл ажиллагааны хүрээнд	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд
1	Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлого (2014-2025)				
2	Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого (2017-2025)				
3	Төрөөс экологийн талаар баримтлах бодлого				
4	Төрөөс малчдын талаар баримтлах бодлого				

5	Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого				
6	Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого				
7	Төрөөс автотээврийн талаар баримтлах бодлого (2018-2026 он)				
8	“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр				

Дээр авч үзсэн салбарын түвшингийн бодлого, хөтөлбөрт гамшгийн эрсдэлийн үйл ажиллагааны “гамшгийн эрсдэлийг ойлгох” чиглэлийн хүрээнд салбар, салбарын ашиг сонирхол, үйл ажиллагааны онцлогийг гаргасан эрсдэл, түүнээс сэргийлэхтэй холбогдох нийтээр даган мөрдөх заалтууд тодорхой хэмжээгээр тусгалаа олсон байна. Энэ нь гамшгийн эрсдэлийн үйл ажиллагааны асуудал олон салбарын оролцоог шаардсан цогц асуудал болохыг харуулахын зэрэгцээ цаашид салбар хоорондын үйл ажиллагааны зохицуулалтад тусгах хэрэгтэйг харуулж байна.

Дүгнэлт

Нэг. Үндсэн хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хуулийн заалтуудын хувьд.

1. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулиас 2020 оныг дуустал хугацаанд батлагдсан, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 800 гаруй хуулиас гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны зүйл заалтыг тусгасан нийтээр даган мөрдөх 50 гаруй хуулийг онцлон авч үүнээс судлахад гамшгийн эрсдэлийн үйл ажиллагааны асуудал бүх салбарын бодлого, үйл ажиллагаанд шаардлагатай болох нь харагдаж байгааг 10 хуулийн жишээн дээр харууллаа.

2. Бүх шатны засаг дарга үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас сэргийлэх, таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг судлан тогтоох, арилгах арга хэмжээг авч, энэ асуудлаар нутаг дэвсгэртээ байгаа үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй албадад чиглэл өгч, холбогдох байгууллагад санал, хүсэлт тавина гэсэн үндсэн хуулийн заалт нь дээрх дүгнэлтийг бататгахын зэрэгцээ орон нутгийн гамшгийн эрсдэлийн менежментэд үндэсний аюулгүй байдлын хангах тусгайлсан чиг үүрэгтэй албад чухал үүрэгтэй байна.

Хоёрт. Бодлогын баримт бичгийн шинжилгээний хувьд:

1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын заалтууд нь үндсэндээ уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг агуулж байгаа бөгөөд гамшгийн эрсдэлийн талаарх үзэл баримтлалын агуулгыг дараах чиглэлүүдээр илэрхийлсэн байна гэж нэгтгэн дүгнэх боломжтой байна. Хүн амыг гамшиг, гэнэтийн бусад аюул, үй олноор устгах

зэвсгийн хөнөөлөөс хамгаалах нь батлан хамгаалах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нэгдсэн төлөвлөлт, нэгдмэл тогтолцоотой байхаар заасан нь улс орны гамшгийн эрсдэлийн үйл ажиллагааны төлөвлөлтөд батлан хамгаалах голлох үүрэгтэй байх ойлголтыг бий болгосон байна.

2. Гамшгийн эрсдэл, түүнийг бууруулах үйл ажиллагааг агуулсан бусад бодлогын баримт бичгийн шинжилгээг бүх салбарын дагаж мөрдөх хөгжлийн бодлого, хөтөлбөр болон тухайн салбарын голлох үүрэг, оролцоотой бодлого гэсэн хоёр чиглэлээр гүйцэтгэж үр дүнгээс нь дараах дүгнэлт хийлээ. Үүнээс нийтээр дагаж мөрдөх бодлого, хөтөлбөрт: “Ногоон хөгжлийн бодлого”, “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”, “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр”, “Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр”, “Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр”, “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”, “Цөлжилттэй дэмжих үндэсний хөтөлбөр” зэрэг олон баримт бичиг байгаа боловч эдгээр бодлого, хөтөлбөрийн зарим нь хүчингүй болсон, хэрэгжилтийн тодорхой үр дүн харагдахгүй байгаа нь эрсдэлийн үйл ажиллагааны төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, гүйцэтгэл, хариуцлага, тайлагнах тогтолцоо муу байгааг харуулж байна.

Нийтээр дагаж мөрдөх бодлого, хөтөлбөрт: “Ногоон хөгжлийн бодлого”, “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”, “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр”, “Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр”, “Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр”, “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”, “Цөлжилттэй дэмжих үндэсний хөтөлбөр” зэрэг олон баримт бичиг байгаа боловч хэрэгжилтийн тодорхой үр дүн харагдахгүй байгаа нь эрсдэлийн менежментийн төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, гүйцэтгэл, хариуцлага, тайлагнах тогтолцоог нэмж тусгах саналтай байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Үндсэн хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. №01. 1992.
2. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. №48. 2010.
3. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. №52. 2020.
4. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. №85. 2015.
5. Монгол УИХ. <http://www.parliament.mn>.
6. ЦЕГ. www.police.gov.mn